



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хэрлэн сумын 12 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ДОА-2020/32-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дорнод аймаг 2020 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: <a href="mailto:Bolortuulb@audit.gov.mn">Bolortuulb@audit.gov.mn</a> Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: <a href="mailto:Tsengelmaav@audit.gov.mn">Tsengelmaav@audit.gov.mn</a> Аудитор: М.Ухаанбилэг Утас: 70584207 Цахим хаяг: <a href="mailto:Ukhaanbilegm@audit.gov.mn">Ukhaanbilegm@audit.gov.mn</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



<b>Аудитын гэрчилгээ</b> .....	3
Аудитын тайлан .....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	8
Менежментийн захидал .....	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	10
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	103
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	114
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	125
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	146
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	157





## 2.1. Оршил

Хэрлэн сумын 12 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал М.Аюушхорлоо танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 112 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 12 дугаар сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 12 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 11-нээс 2020 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор М.Ухаанбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Хэрлэн сумын 12 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Хэрлэн сумын 12 дугаар сургууль нь “Ерөнхий боловсролын суурь, бүрэн дунд боловсролыг чанартай эзэмшүүлэх” гэсэн эрхэм зорилгыг хүрээнд ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хэрлэн сумын 12 дугаар сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Асолюс программ хангамж ашигладаг байна.

Хэрлэн сумын 12 дугаар сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Хэрлэн сумын 12 дугаар сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 946,139.0 мянган төгрөгөөс тооцон 18,922.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 22,478.6 мянган төгрөгөөр өсгөсөн нь тайлант онд санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой болно.

## **2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Хэрлэн сумын 12 дугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,135.9 мянган төгрөгөөр өссөн байна. Материаллаг хэмжээний өөрчлөлт орсон хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	129,694.0	158,818.9	29,124.8
Үндсэн хөрөнгө	1,818,770.1	1,834,134.0	15,363.8
Элэгдэл	-147,145.3	-198,454.0	-50,624.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,800,634.9</b>	<b>1,794,498.9</b>	<b>6,135.9</b>
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,800,634.9	1,794,498.9	6,135.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,800,634.9</b>	<b>1,794,498.9</b>	<b>6,135.9</b>

Бараа материалын дансны үлдэгдэл өмнө оноос өссөн нь БСШУСЯ-наас үнэ төлбөргүй ирүүлсэн сурах бичгийн дүнгээр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ. БСШУСЯ-наас 935,7 мянган дотоод сүлжээний утас, аймгийн ОНХС-аас 6061,0 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, Хэрлэн сумын ЗДТГ-аас гэрэлтүүлэгт 6000,0 сая төгрөгөөр нэмэгдсэн дүнгээр тус тус нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо буурсан нь тайлант оны үр дүн алдагдалтай гарснаас шалтгаалсан байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хэрлэн сумын 12 дугаар сургууль нь орлого төвлөрүүлдэггүй тул орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 1,069,716.3 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,042,416.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 27,300.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,069,185.2 мянган төгрөг буюу 100,0 хувьтай байна.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны төсвийн захирагч БСУГ-аар дамжин Дэлхийн банкны санхүүжилтээр Амжилтын өртөө төсөлд 10,920.5 мянган төгрөгийн санхүүжилт болон өөрийн орлого болох тендерийн баримт бичиг, заалны түрээсийн орлого 388,5 мянган төгрөгөөр нэмэлт төсөв бүрдүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтээс амжилтын өртөө төслийн хүрээнд тээвэр шатахуун 150.0 мянган төгрөг, Ном, хэвлэл 327.5 мянган төгрөг, урсгал засварт 214.0 мянган төгрөг, дотоод албан томилолт 548.0 мянган төгрөг, Бараа үйлчилгээний бусад зардал 2,270.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 321.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 12 эрсдэл тодорхойлж нийт 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 10,876.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 6,000.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 411.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 4,464.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 411.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага тогтоолоо. Үүнд:

1. Сургуулийн хүүхдийн хоолны хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчийн тендерийн баримт бичигт тусгагдсан үнийн саналаас давсан үнээр худалдан авалт хийсэн зөрчил илэрсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40.4-т "Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоног төхөөрөмж, үндсэн материал, түүхий эд, хөдөлмөрийн хөлсний үнэд захиалагч дараах тохиолдолд тохируулга хийхээр гэрээнд тусгаж болно:" үүнд 40.4.1-т "хоёр жилээс дээш хугацаанд хэрэгжих гэрээний явцад хэрэглээний үнийн индекс өөрчлөгдсөн;", 40.4.2-т "суурь үнэ огцом өөрчлөгдсөн., 41.1.2-т "энэ хуулийн 40.4-т зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөх."-ийг хориглох тухай заалттай нийцэхгүй ба санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг, хэмжилт гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага

Аудитаар илэрсэн 4,464.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 2.12. Шилэн дансны мэдээлэл

Хэрлэн сумын 12 дугаар сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдээс хугацаа хоцроосон болон оруулаагүй мэдээлэл байхгүй байна.

## 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн ебаримтад бүртгүүлж ажиллах зөвлөмжийн биелэлт 95.8 хувьтай байна.

## 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хэрлэн сумын 12 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

Хэрлэн сумын 12 дугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг НББ-ийн тухай хуулийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын **агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс** урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1. Бараа материалын данстай холбоотой асуудал*

*1.1. Илрүүлэлт:*

Тайлант онд хийсэн төлбөр төлөлтийн дүн 106.0 сая төгрөгийн 95.8 хувь буюу 101.6 сая төгрөгийн дүнтэй худалдан авалт ебаримтад бүртгэлтэй байна. Цаашид Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан зааврын мөрдөж ажиллах.

*1.2. Эрсдэл:*

Бүртгэл бүрэн үнэн, зөв хөтлөгдөхгүй байх.

*1.3. Өгсөн зөвлөмж:*

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг мөрдөж ажиллах

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>129,694,097.32</u></b>	<b><u>164,818,912.15</u></b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	129,694,097.32	164,818,912.15
351	Түүхий эд материал	00.00	00.00
354	Хангамжийн материал	129,694,097.32	164,818,912.15
35410	Бичиг хэргийн материал	162,225.00	1,570,955.00
35420	Аж ахуйн материал	2,523,158.00	12,375,188.00
35470	Бусад хангамжийн материал	127,008,714.32	150,872,769.15
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,670,940,821.81</u></b>	<b><u>1,629,680,020.81</u></b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,670,940,821.81	1,629,680,020.81
392	Биет хөрөнгө	1,465,713,655.44	1,424,443,520.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,370,846,245.10	1,370,846,245.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-23,361,194.88
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	145,865,361.20	152,049,496.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-108,730,625.09	-124,217,975.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	81,070,589.00	84,013,789.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-38,337,914.77	-46,136,839.98
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,000,000.00	15,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-3,750,000.00
393	Биет бус хөрөнгө	205,227,166.37	205,236,500.00
39301	Програм хангамж	988,000.00	1,224,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-760,833.63	-988,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	205,000,000.00	205,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,800,634,919.13</u></b>	<b><u>1,794,498,932.96</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,800,634,919.13</u></b>	<b><u>1,794,498,932.96</u></b>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,800,634,919.13	1,794,498,932.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	442,534,825.40	442,534,825.40
51101	Өмч: - төрийн	442,534,825.40	442,534,825.40
512	Хуримтлагдсан үр дүн	1,291,016,863.34	1,284,880,877.17
51210	Өмнөх үеийн үр дүн	1,291,016,863.34	1,291,016,863.34
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-6,135,986.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	67,083,230.39	67,083,230.39
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,800,634,919.13</u></b>	<b><u>1,794,498,932.96</u></b>

#### 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>948,241,637.70</b>	<b>1,117,798,125.13</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>73,292,637.70</b>	<b>37,161,325.13</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	51,106,437.70	25,560,350.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	51,106,437.70	25,560,350.43
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	51,106,437.70	25,560,350.43
<b>121</b>	<b>Хөрөнгийн орлого</b>	22,186,200.00	11,600,974.70
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	22,186,200.00	11,600,974.70
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>10,446,400.00</b>	<b>38,220,500.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	864,502,600.00	1,042,416,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	10,446,400.00	10,920,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,246,400.00	10,532,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	200,000.00	388,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	27,300,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	27,300,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>946,139,006.76</b>	<b>1,123,934,111.30</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>946,139,006.76</b>	<b>1,123,934,111.30</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	838,813,381.26	1,058,132,889.30
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	643,808,445.98	849,727,100.00
210101	Үндсэн цалин	500,248,445.98	624,913,000.00
210102	Нэмэгдэл	104,660,000.00	141,323,200.00
210104	Урамшуулал	38,900,000.00	83,490,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	77,529,913.00	106,215,700.00
210201	Тэтгэврийн даатгал	51,686,874.00	72,226,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,354,514.00	8,497,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,276,568.00	6,797,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,291,988.00	1,699,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,919,969.00	16,994,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	22,960,967.00	24,296,098.00
210301	Гэрэл, цахилгаан	4,433,340.00	4,259,031.00
210302	Түлш, халаалт	13,569,147.00	13,849,172.00
210303	Цэвэр, бохир ус	4,958,480.00	6,187,895.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,921,963.15	8,914,473.60
210401	Бичиг хэрэг	1,382,235.00	1,513,050.00
210402	Тээвэр, шатахуун	1,140,100.00	1,274,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,409,658.50	1,456,390.00
210404	Ном, хэвлэл	8,963,411.65	885,804.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	450,550.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,026,558.00	3,334,079.60
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	200,000.00	602,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200,000.00	270,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	332,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,004,700.00	2,484,000.00
210604	Урсгал засвар	5,004,700.00	2,484,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	680,000.00	1,264,400.00
210702	Дотоод албан томилолт	680,000.00	1,264,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	960,000.00	3,228,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	960,000.00	3,048,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	180,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	70,747,392.13	61,400,617.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	1,321,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,652,503.00	5,573,842.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	57,394,889.13	54,505,275.70
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	107,325,625.50	65,801,222.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	107,251,010.00	65,270,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	61,126,010.00	62,864,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,818,400.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	23,106,600.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,200,000.00	2,405,800.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	74,615.50	531,022.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	74,615.50	531,022.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>2,102,630.94</b>	<b>-6,135,986.17</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	27,762,476.10	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	21,002,800.65	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	6,759,675.45	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-27,762,476.10	00.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-25,659,845.16</b>	<b>-6,135,986.17</b>

#### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>874,949,000.00</b>	<b>1,080,636,800.00</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>874,949,000.00</b>	<b>1,080,636,800.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	864,502,600.00	1,042,416,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	10,446,400.00	10,920,500.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,246,400.00	10,532,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	200,000.00	388,500.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	27,300,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	27,300,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>874,949,000.00</b>	<b>1,080,636,800.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>874,949,000.00</b>	<b>1,080,636,800.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>767,623,374.50</b>	<b>1,014,835,578.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	646,084,650.00	849,727,100.00
210101	Үндсэн цалин	502,524,650.00	624,913,000.00
210102	Нэмэгдэл	104,660,000.00	141,323,200.00
210104	Урамшуулал	38,900,000.00	83,490,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	77,529,913.00	106,215,700.00
210201	Тэтгэврийн даатгал	51,685,413.00	72,226,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,461,100.00	8,497,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,168,900.00	6,797,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,292,200.00	1,699,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,922,300.00	16,994,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	22,960,967.00	24,296,098.00
210301	Гэрэл, цахилгаан	4,433,340.00	4,259,031.00
210302	Түлш, халаалт	13,569,147.00	13,849,172.00
210303	Цэвэр, бохир ус	4,958,480.00	6,187,895.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,820,984.50	11,776,900.00
210401	Бичиг хэрэг	972,030.00	1,517,190.00
210402	Тээвэр, шатахуун	1,140,100.00	1,274,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,409,658.50	1,456,390.00
210404	Ном, хэвлэл	475,000.00	1,094,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	450,550.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,824,196.00	5,984,070.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	200,000.00	1,074,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200,000.00	270,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	804,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,000,000.00	3,214,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	3,214,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	680,000.00	1,264,400.00
210702	Дотоод албан томилолт	680,000.00	1,264,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,998,000.00	3,465,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,998,000.00	3,285,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	180,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,348,860.00	13,801,780.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	1,321,500.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,648,860.00	12,480,280.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>107,325,625.50</b>	<b>65,801,222.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	107,251,010.00	65,270,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	61,126,010.00	62,864,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,818,400.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	23,106,600.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,200,000.00	2,405,800.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	74,615.50	531,022.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	74,615.50	531,022.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>442,534,825.40</b>	<b>67,083,230.39</b>	<b>1,291,016,863.34</b>	1,800,634,919.13
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>442,534,825.40</b>	<b>67,083,230.39</b>	<b>1,291,016,863.34</b>	1,800,634,919.13
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-6,135,986.17	-6,135,986.17
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>442,534,825.40</b>	<b>67,083,230.39</b>	<b>1,284,880,877.17</b>	1,794,498,932.96

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,069,716,300.00	1,069,185,278.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,069,716,300.00	1,069,185,278.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,003,919,000.00	1,003,915,078.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	849,727,100.00	849,727,100.00
210101	Үндсэн цалин	624,913,000.00	624,913,000.00
210102	Нэмэгдэл	141,323,200.00	141,323,200.00
210104	Урамшуулал	83,490,900.00	83,490,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	106,215,700.00	106,215,700.00
210201	Тэтгэврийн даатгал	72,226,600.00	72,226,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,497,400.00	8,497,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,797,700.00	6,797,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,699,400.00	1,699,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,994,600.00	16,994,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	24,300,000.00	24,296,098.00
210301	Гэрэл, цахилгаан	5,000,000.00	4,259,031.00
210302	Түлш, халаалт	14,800,000.00	13,849,172.00
210303	Цэвэр, бохир ус	4,500,000.00	6,187,895.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,299,400.00	11,299,400.00
210401	Бичиг хэрэг	1,432,800.00	1,517,190.00
210402	Тээвэр, шатахуун	936,000.00	1,124,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,450,000.00	1,456,390.00
210404	Ном, хэвлэл	766,600.00	766,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,500.00	450,550.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,213,500.00	5,984,070.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,074,600.00	1,074,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	270,000.00	270,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	804,600.00	804,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	716,400.00	716,400.00
210702	Дотоод албан томилолт	716,400.00	716,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,195,000.00	1,195,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,015,000.00	1,015,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6390800.00	6390780.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	1,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,390,800.00	5,390,780.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	65797300.00	65270200.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	65,797,300.00	65,270,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	63,391,500.00	62,864,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,405,800.00	2,405,800.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,069,716,300.00	1,069,716,300.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,042,416,300.00	1,042,416,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,042,416,300.00	1,042,416,300.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	27,300,000.00	27,300,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	27,300,000.00	27,300,000.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00